

Олон Улсын Археологчидын Зургаадах Удаагийн Конгрест Урьж Байна.

Та бүхнийг 2008 оны 6 сарын 29-өөс 7 сарын 4нд болох ОУА-ын Зургаадах Удаагийн Конгрест урьж байна. Энэ удаагийн конгрес Дублин хотын урд төвд орших Дублины Коллеж Их Сургууль дээр зохиогдох юм. Энэхүү өргөн сэдэвт, олон талт сонирхолтой арга хэмжээний хөтөлбөрт хэрхэн оролцох талаарх мэдээллийг манай вебсайт <http://www.ucd.ie/wac-6> -руу орж сонирхоно уу.

Энэхүү конгрест танилцуулах илтгэлийн хураангуй эсвэл дэлгэн үзүүлэх самбарын хуудасыг 2008 оны 2 сарын 22-оос өмнө хүлээн авах бөгөөд эдгээрийг манай вебсайтын **Submit Proposals** хуудаснаас интэрнетээр илгээнэ үү. Та бүхнийг бүтээлээ дээрх хугацаанаас өмнө аль болох яаралтай явуулахыг бид санал болгож байна.

Конгресийн бүртгэлийн хураамжийн талаарх мэдээллийг манай вэбсайтаас олж үзнэ үү. Энэхүү хураамж нь ОУАК-ийн гишүүдэд хөнгөлөлттэй тул гишүүн бус оролцогчдыг гишүүнд элсэхийг зохион байгуулагчдын зүгээс санал болгож байна. Гишүүнчлэлийг талаарх мэдээллэл конгресийн вэбсайт <http://worldarchaeologicalcongress.org/site/join.php> -т байгаа болно.

Энэ удаагийн ОУАК нэг гол зорилго нь аль болох олон улсын төлөөлөгчдийг оролцуулж өргөн хүрээг хамрах явдал юм. Үүнтэй холбоотойгоор буурай болон хөгжингүй орнуудын төлөөлөгчдийг үнэгүй бүртгэх, байрлуулах түүнчлэн замын зардалд нь хөнгөлөлт үзүүлэхдээ бид таатай байх болно. Та энэ асуудлаар хандахыг хүсвэл дараах вэбсайт руу орж үзнэ үү. <http://www.ucd.ie/wac-6>.

Энэ удаагийн конгрест урлаг ба археологийн харилцан уялдааг харуулсан томоохон бүтээл болох *Abhar agus Meon* буюу Материал болон Оюун Ухаан зэрэг олон бүтээлийн үзэсгэлэн оролцож байгаа юм. Үүний хажуугаар та хөтөлбөрийн олон арга хэмжээнд оролцож, 7-р сарын 2-ны Лхагва гаригт болох Конгресийн завсрын тойрон аялалд явж Ирланд улсын археологийн баялаг өв уламжлалтай танилцан хүсвэл Конгресийн дараах 3 аялалд оролцож болно.

Конгресийн хөтөлбөрийн талаар лавлахыг хүсвэл wac6programme@ucd.ie хаягаар, бүртгэл, байр, Ирланд улсын визний талаарх асуудлаар wac6@ucd.ie хаягаар тус тус хандана уу.

Та бүхэнтэй Дублин хотноо уулзана гэдэгт найдаж байна.
ОУА-н 6 дах Конгресийг төлөөлж хүндэтгэсэн Габриэл Куни (Gabriel Cooney).

Чухал өдрүүд

2008 оны 2 сарын 22 Илтгэлийн хураангуй эсвэл самбарын танилцуулах хуудас авах сүүлийн өдөр.

2008 оны 3 сарын 14 Оролцохоор шалгарсан бүтээлийн сүүлийн баталгаажуулалт. (тэтгэлэг хүсэх зорилгоор илтгэл нь шалгарсан эсэх мэдэгдлээ эрт авахыг хүссэн оролцогчид дараах хаягаар хандана уу, wac6programme@ucd.ie).

2008 оны 3 сарын 26-аас өмнө
2008 оны 3 сарын 26-аас хойш
2008 оны 5 сарын 1

Эрт бүртгэлийн цаад хугацаа
Орой бүртгэлийн цаад хугацаа
Зохион байгуулагчид болон илтгэгчдийг
бүртгэх цаад хугацаа